



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5 дугаар хуралдааны тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 2.15 дахь заалтын "Дөргөн суманд хог, хаягдал зайлуулах, булах универсаль ковш авах", 2.16 дахь заалтын "Мөнххайрхан суманд ковш авах" ажлуудтай танилцаж шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч : С.Гантөмөр

- Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд : Т.Заяа

- Дөргөн сумын Засаг дарга

Б.Батболд

- Мөнххайрхан сумын Засаг дарга

Б.Түмэндэмбэрэл – Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

П.Улаанхүү

- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч /зөвшилцсөн/

Д.Балт

- Авто тээврийн төвийн шинжээч

Нарийн бичгийн

дарга: Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. "Онхотын булаг" ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын даалгавартай тулган шалгаж өмч бүртгэлд тусгах, хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч С.Гантөмөрт даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД